



МОНГОЛ УЛСЫН
ДАЛАЙН ЗАХИРГААНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2026 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/133

Улаанбаатар хот

Байгууллагын эцэг, эхийн зөвлөлийн
бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж, ажиллах
журмыг батлах тухай

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3, 30.4 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэг, Монгол Улсын Далайн захиргааны дүрмийн 3 дугаар зүйлийн 3.6 дахь хэсэг, Хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Байгууллагын эцэг, эхийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, Зөвлөлийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Байгууллагын хэмжээнд хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн, биелэлтийг холбогдох дээд шатны байгууллагад хагас, бүтэн жилээр тайлагнахыг Эцэг, эхийн зөвлөлийн дарга (Б.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Далайн захиргааны даргын 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/64 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



М.ӨЛЗИЙ

1426010341

[illegible]

התורה והנביאים

၂၀၁၈ ခုနှစ်

3/22/20

2025 06 03 03

دستور و انتخابات مجلس

[illegible]

۶. **مستحقان** در **مستحقان** . بر **مستحقان** در **مستحقان** .

١٢٤٥٦٧٨٩١٠١١١٢١٣١٤١٥١٦١٧١٨١٩٢٠٢١٢٢٢٣٢٤٢٥٢٦٢٧٢٨٢٩٣٠٣١٣٢٣٣٣٤٣٥٣٦٣٧٣٨٣٩٤٠٤١٤٢٤٣٤٤٤٥٤٦٤٧٤٨٤٩٥٠٥١٥٢٥٣٥٤٥٥٥٦٥٧٥٨٥٩٦٠٦١٦٢٦٣٦٤٦٥٦٦٦٧٦٨٦٩٧٠٧١٧٢٧٣٧٤٧٥٧٦٧٧٧٨٧٩٨٠٨١٨٢٨٣٨٤٨٥٨٦٨٧٨٨٨٩٩٠٩١٩٢٩٣٩٤٩٥٩٦٩٧٩٨٩٩١٠١١١٢١٣١٤١٥١٦١٧١٨١٩٢٠٢١٢٢٢٣٢٤٢٥٢٦٢٧٢٨٢٩٣٠٣١٣٢٣٣٣٤٣٥٣٦٣٧٣٨٣٩٤٠٤١٤٢٤٣٤٤٤٥٤٦٤٧٤٨٤٩٥٠٥١٥٢٥٣٥٤٥٥٥٦٥٧٥٨٥٩٦٠٦١٦٢٦٣٦٤٦٥٦٦٦٧٦٨٦٩٧٠٧١٧٢٧٣٧٤٧٥٧٦٧٧٧٨٧٩٨٠٨١٨٢٨٣٨٤٨٥٨٦٨٧٨٨٨٩٩٠٩١٩٢٩٣٩٤٩٥٩٦٩٧٩٨٩٩

[illegible][illegible]

۳.. نیز که مذهب و اقتصاد در رابطه مستقیم نیستند بلکه هر دوی آن در دست خداست و انسان باید به او توجه کند و از او بترسد و از او بگردد.

जिम्मा

٥٠٠



1426020205

Монгол Улсын Далайн захиргааны даргын
2026 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн
А/133 дугаар тушаалын Нэгдүгээр хавсралт

Эцэг эхийн зөвлөлийн бүрэлдэхүүн



Эцэг эхийн зөвлөлийн дарга:

Б.Мөнхбат

Далайн тээвэр, хуурай боомтын хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:

Н.Долгор

Хуурай боомтын гадаад худалдаа, хөрөнгө оруулалт
хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Д.Энхмандах

Хүний нөөц, сургалт хариуцсан мэргэжилтэн

Ж.Ханбаатар

Далбааны эзэн улсын хяналт, шалгалт хариуцсан
мэргэжилтэн

Г.Хүрэлтулга

Усан замын тээврийн хяналт, сургалт хариуцсан
мэргэжилтэн

Б.Гэрэлтуул

Санхүү, аж ахуй хариуцсан мэргэжилтэн

---oOo---

БАЙГУУЛЛАГЫН ЭЦЭГ, ЭХИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Монгол Улсын Далайн захиргааны дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн тухай конвенц, түүнчлэн Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр зэрэг холбогдох хууль тогтоомж, баримт бичгийг үндэслэн Монгол Улсын Далайн захиргаа (цаашид "Байгууллага" гэх)-ны эцэг, эхийн зөвлөл (цаашид "Зөвлөл" гэх)-ийн бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлоход оршино.

1.2. Зөвлөл нь байгууллагын албан хаагчдын хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах, хүүхдийг аливаа эрсдэл, хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх, эцэг эх, хүүхдийн зөв харилцаа, эерэг нийгмийн хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр ажил зохион байгуулах эцэг, эхийн төлөөлөл юм.

1.3. Журамд заагаагүй асуудлыг Зөвлөл холбогдох хууль тогтоомж, байгууллагын удирдлагатай зөвшилцөн шийдвэрлэнэ.

Хоёр. Зөвлөлийн зорилго, үндсэн зарчим

2.1. Зөвлөлийн үйл ажиллагааны зорилго нь дараах чиглэлүүдтэй.

2.1.1. хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хөгжих эрхийг хангасан хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх;

2.1.2. эцэг эх, асран хамгаалагч, хамт олныг хүүхдийг хамгаалах, дэмжих үйл ажиллагаанд идэвхтэй татан оролцуулах;

2.1.3. хүүхдийн эсрэг хүчирхийлэл, мөлжлөг, дарамт, үл хайхрах байдлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг эрт илрүүлэх;

2.1.4. гэр бүлийн эерэг харилцаа, хүүхэд хүмүүжүүлэх зөв арга барилыг сурталчлах, дэмжлэг үзүүлэх.

2.2. Зөвлөл үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална.

2.2.1. хүүхдийн эрхийг дээдэлж, хүүхдийн язгуур эрх ашгийг эн тэргүүнд тавих;

2.2.2. хүүхдийн эсрэг хүчирхийллийн аливаа хэлбэрийг ямар нэгэн шалтгаанаар ч хүлээн зөвшөөрөхгүй байх;

2.2.3. ил тод, хариуцлагатай, хамтын оролцоонд суурилах;

2.2.4. хүүхэд, гэр бүлтэй холбоотой хувийн болон нууц мэдээллийг задруулахгүй, хадгалалтын нууцлалыг чандлан сахих.

Гурав. Зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт

3.1. Зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр ажиллах бөгөөд бүрэлдэхүүнийг Байгууллагын даргын тушаалаар 2 (хоёр) жилийн хугацаагаар томилно.

3.2. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Байгууллагын хэлтэс, албадын төлөөллийг оролцуулан, ажилтнуудын саналд үндэслэн бүрдүүлнэ.

3.3.Зөвлөлийн даргыг гишүүдийн олонхын саналаар сонгох буюу байгууллагын даргын шийдвэрээр томилно.

3.4.Зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах шаардлага гарвал Зөвлөлийн саналыг үндэслэн байгууллагын даргын тушаалаар баталгаажуулна.

3.5.Зөвлөл нь тодорхой чиглэлээр ажиллах түр ажлын хэсгийг Зөвлөлийн гишүүнээр ахлуулан байгуулж, тодорхой хугацаагаар ажиллуулж болно.

Дөрөв. Зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүний чиг үүрэг

4.1.Зөвлөлийн дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

4.1.1.гишүүдийн ажил үүргийн хуваарийг батлан мөрдүүлэх;

4.1.2.Зөвлөлийн хурлыг товлон зарлаж, даргалах;

4.1.3.Зөвлөлийн хурлын шийдвэр, үйл ажиллагааны үр дүнгийн талаар Байгууллагын удирдлагад тогтмол мэдээлэх;

4.1.4.хүүхдийн аюулгүй байдалд шууд аюул учирсан яаралтай тохиолдолд байгууллагын удирдлага, холбогдох байгууллагад шуурхай мэдэгдэх.

4.2.Нарийн бичгийн дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

4.2.1.Зөвлөлийн хурлыг зохион байгуулах, гишүүдэд хуралдахаас өмнө урьдчилан мэдэгдэж, холбогдох баримт бичгийг хүргүүлэх;

4.2.2.хурлын тэмдэглэл хөтлөх, баталгаажуулах, архивлан хадгалах;

4.2.3.Зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой бичиг баримт, төлөвлөгөө гаргах, судалгаа хийх, тайланг хөтлөх, бэлтгэх;

4.2.4.Хүүхэд хамгааллын бодлогод заасан хэрэгжүүлэх ажлыг (сургалт зохион байгуулах, ажилтан шалгаруулах баримт бичиг бүрдүүлэх, зөрчлийн бүртгэл хөтлөх, эрсдэлийн хяналтын хороотой хамтран ажиллах зэрэг) уялдуулан зохион байгуулж, хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх тайланг хагас, бүтэн жилээр боловсруулж, тайлагнах.

4.2.5.Зөвлөлийн нарийн бичгийн даргад албан тушаалын тодорхойлолтод заагаагүй нэмэлт ажил, үүргийг хавсран гүйцэтгүүлж байгаа тул холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн үндсэн цалингийн 20 хувиар тооцож, нэмэгдэл хөлс олгоно.

4.3.Зөвлөлийн гишүүн дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

4.3.1.зөвлөлийн хурлын шийдвэрийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээнд оролцох;

4.3.2.зөвлөлийн дарга буюу хурлаас хариуцуулсан ажил, даалгаврыг хугацаанд нь чанартай биелүүлж, дүнг хуралд мэдээлэх;

4.3.3.хариуцсан чиглэлийн хүрээнд байгууллагын ажилтнуудын хүүхдийн сурч боловсрох, аюулгүй орчинд өсөж хүмүүжиж буй эсэхтэй танилцах, туслах, зөвлөх үйл ажиллагаанд оролцох;

4.3.4.зөвлөлийн хуралд асуудал оруулж хэлэлцүүлэх, шийдвэрийн хэрэгжилттэй танилцаж, тайлбар гаргуулах.

Тав. Хурал зохион байгуулах.

5.1.Зөвлөл жилд 2 (хоёр)-оос доошгүй удаа ээлжит хуралдана.

5.2.Ажлын шаардлага гарсан тохиолдол бүрд Зөвлөлийн даргын санаачилгаар, эсхүл гишүүдийн 50-иас доошгүй хувийн саналаар ээлжит бус хурал хуралдуулж болно.

5.3.Хурлын товыг хуралдахаас 3 (гурав)-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд мэдэгдэж, хэлэлцэх асуудалтай холбогдох баримт бичгийг урьдчилан хүргүүлнэ.

5.4.Хурлыг гишүүдийн 75 (далан тав)-аас доошгүй хувийн ирцтэй бол хүчинтэйд тооцно.

5.5.Хурлын шийдвэрийг хуралд оролцогчдын олонхын саналаар гаргана. Санал тэнцсэн тохиолдолд Зөвлөлийн даргын саналаар эцэслэн шийдвэрлэнэ.

5.6.Хурлын тэмдэглэл үйлдэх бөгөөд тэмдэглэлд Зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, тэмдэглэл хөтөлсөн гишүүн гарын үсэг зурж баталгаажуулна.

Зургаа. Хүүхэд хамгааллын үйл ажиллагаа, зөрчил мэдээлэх.

6.1.Байгууллагын ажилтан, албан хаагч бүр хүүхдийн эсрэг аливаа хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхрах шинжтэй үйлдэл, зан үйлийг ажигласан, сэжиглэсэн тохиолдолд энэ тухай Зөвлөлийн даргад нэн даруй мэдээлэх үүрэгтэй.

6.2.Зөвлөл хүлээн авсан мэдээллийн нууцыг чандлан хадгалж, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн аюулгүй байдлыг эн тэргүүнд хангахад чиглэсэн арга хэмжээг шуурхай авна.

6.3.Асуудал гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй бол Зөвлөл цагдаа, хууль хяналтын байгууллага, орон нутгийн эрх бүхий хүүхэд хамгааллын байгууллагад холбон зуучилж, хамтарсан багт мэдэгдэнэ.

6.4.Зөрчлийн шинжгүй боловч эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тухай мэдээллийг Зөвлөл Байгууллагын дүрэм, журмын дагуу шийдвэрлэж, шаардлагатай бол Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хүүхдийн тусламжийн 108 утас зэрэг холбогдох байгууллагатай хамтран ажиллана.

6.5.Байгууллагын үйл ажиллагаа, орчин нь хүүхдэд хор хөнөөл учруулж болзошгүй эсэхэд Зөвлөл тогтмол үнэлгээ хийж, эрсдэлийг бууруулах, арилгах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

6.6.Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийг зөрчсөн ажилтанд Зөвлөл зөвлөх, засаж сургах арга хэмжээ авах, эсхүл асуудлыг эрх бүхий албан тушаалтан, хөдөлмөрийн зөрчил хянан шийдвэрлэх журмын дагуу шилжүүлэн шийдвэрлүүлнэ.

Долоо. Урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгаа

7.1.Зөвлөл нь байгууллагын ажилтнуудад хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын хууль тогтоомж, хүүхдийн эсрэг хүчирхийллийг таньж мэдэх, гэр бүлийн эерэг харилцааны талаар жилд 2-оос доошгүй удаа сургалт зохион байгуулна.

7.2.Байгууллага шинээр ажилд авах ажилтныг сонгон шалгаруулахдаа хүүхдэд хор хохирол учруулж болзошгүй хүнийг ажилд орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор хуулиар зөвшөөрөгдсөн журмын дагуу шалгуулна.

7.3.Нийт ажилтан, шинээр ажилд орж байгаа ажилтан, албан хаагч Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрэмтэй танилцаж, дүрмийг хүлээн зөвшөөрсөн тухай баримтад гарын үсэг зурж баталгаажуулна.

7.4.Зөвлөл нь байгууллагын мэдээллийн самбар, цахим хуудсаар дамжуулан хүүхэд хамгааллын талаарх мэдээ, зөвлөмжийг хүргэнэ.

Найм. Тайлагналт

9.1.Зөвлөл нь хийсэн ажлын тайланг жил бүр гаргаж, Байгууллагын удирдлага, хамт олны хуралд танилцуулна.

9.2.Зөвлөлийн дарга байгууллагын хэмжээнд хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний биелэлтийг холбогдох дээд шатны байгууллагад бүтэн жилээр тайлагнана.

Ёс. Бусад зүйл

9.1.Энэхүү журмыг байгууллагын даргын тушаалаар баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

9.2.Журамд өөрчлөлт оруулах саналыг Зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар гаргаж, Байгууллагын даргад танилцуулан шийдвэрлүүлнэ.

9.3. Байгууллагын эцэг эхийн зөвлөл нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй.

---oOo---